



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2023 оны 05 сарын 02 өдөр

Дугаар 28

Мөрөн сум

“Их-Уул дулаан” ХХК-ийн жилийн үйл
ажиллагааны болон санхүүгийн тайлангийн
талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт,
Төлөөлөн удирдах зөвлөлийн ажлын тайлангийн
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9, “Их-Уул Дулаан” ХХК-ийн дүрмийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит XVIII хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолоор өгсөн дүгнэлтийг дэмжихгүй байхаар баталсугай.

2.Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны үйл ажиллагааны үр дүнг “хангалтгүй” гэж дүгнэсүгэй.

3.“Их-Уул Дулаан” ХХК-ийн ерөнхий нягтлан бодогчид хариуцлага тооцож Төлөөлөн удирдах зөвлөлд тайлагнаж ажиллахыг гүйцэтгэх захиралд даалгасугай.

4.“Их-Уул Дулаан” ХХК-ийн гүйцэтгэх захиралд хариуцлага тооцож ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлд үүрэг болгосугай.

5.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Н.Төмөрхуяг)-д даалгасугай.

ДАРГА



Г.МӨНГӨНХУЯГ

6712001016